

“ТАТВАРЫН БҮРТГЭЛ” УЛСЫН XI ОЛИМПИАДЫН **УДИРДАМЖ /төсөл/**

Нэг: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ЗОРИЛГО: Олимпиадад оролцогчдын татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг ур чадварыг сорих, мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, заавар стандартын талаарх мэдлэгийг дээшлүүлж, хэрэглээ болгон идэвхжүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ: Нягтлан бодогч, санхүүч, татварын улсын байцаагч, их дээд сургуулиудын оюутан залуус хамрагдах бөгөөд оролцогчдыг дараах 2 бүлэгт хуваана.

1-р бүлэг: Их, дээд сургуульд нягтлан бодох бүртгэл, татвар, санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнууд

2-р бүлэг: Нягтлан бодогч, татварын улсын байцаагч болон бусад
/олимпиадад оролцохыг хүссэн хүн бүрд нээлттэй/

ХУГАЦАА: Олимпиадыг 2 үе шаттай зохион байгуулна.

1-р шат: 2024 оны 10-р сарын 09-нд

2-р шат: 2024 оны 10-р сарын 18-нд

БҮРТГЭЛ: Олимпиадын бүртгэлийг www.members.cpta.mn цахим хуудсаар 2024 оны 09-р сарын 02-ны 10:00 цагаас эхэлж, 2024 оны 09-р сарын 23-ны 10:00 цаг хүртэл бүртгэнэ.

Хоёр: ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэгдүгээр үе шат:

- Оролцогч нь байгаа газраасаа интернэтэд холбогдон цахимаар оролцоно.
- Олимпиадын эхлэх, дуусах хугацааг урьдчилан тохируулсан байх тул зөвхөн товлосон хугацаанд оролцох боломжтой.
- Мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын талаарх мэдлэгийг шалгах 50 энгийн асуулт, 50 бодолттой асуулт байна.
- Олимпиадын явцыг шүүгчид камераар хянах тул оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - Суурин компьютер эсвэл нөүтбүүк (цаашид “компьютер” гэх)-тэй байна.
 - Компьютер, интернэт болон цахилгааны найдвартай холболтыг хангасан байна.
 - Компьютерын техникийн хамгийн доод үзүүлэлт нь дараах нөхцөлтэй байна.
CPU: INTEL CORE i5 5200, RAM 4GB, Үйлдлийн систем Windows 7-оос дээш байна.
 - Компьютер нь заавал камер болон микрофон чихэвчтэй холбогдсон байна.

- Найдвартай, хурдтай интернэт орчинд байх бөгөөд интернэт холболтын өгөгдөл дамжуулах (upload хийх) хурд нь 4Mbps болон түүнээс дээш байна. Интернэтийн хурдаа <http://speedof.me/> сайтруу орж шалгасан байна.
 - Компьютер дээр Google Chrome хөтөч татаж суулгасан байна.
 - Тэмцээнд оролцох компьютер Dinamic системд нэвтэрсэн байна. Системд зөвхөн нэг төхөөрөмжөөс нэвтрэх ба өөр төхөөрөмж давхар хандалт өгсөн тохиолдолд систем хаагдана.
 - Оролцогч нь олимпиад эхлэхээс 30 минутын өмнө хувийн болон техникийн бэлтгэлээ бүрэн хангасан байна.
 - Оролцогчдыг шалгалтын комисс www.jitsi.meeting.mn-ээр дамжуулж хянах болно.
5. Олимпиадад оролцогч нарт хориглох зүйлс
- Оролцогчид шалгалтын явцад дэлгэцийг хаах, өөр цонх нээх, хориглоно.
 - Оролцогчид шалгалтын дундуур босож явахгүй байх хувийн бэлтгэлээ хангасан байна.
 - Оролцогч нь шалгалт өгөх өрөөнд зөвхөн ганцаараа байна.
 - Олимпиадын үед хуулах оролдлого хийсэн оролцогчийг шалгалтаас хасна.
6. Шалгалтын түр горимыг татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн эрх олгох шалгалтын түр горимыг баримталж явуулна.
Шалгалтын түр горимтой www.cpta.mn сайтын сургалт, шалгалт цэсрүү орж дэлгэрэнгүй танилцана уу.

Хоёрдугаар үе шат:

1. Нэгдүгээр шатны шалгаруулалтын бүлэг тус бүрээс хамгийн өндөр оноо авсан оролцогчдын 20% нь 2-р үе шатанд оролцох эрх авна.
2. Олимпиадын хоёрдугаар үе шатанд шалгарсан оролцогчдыг www.cpta.mn цахим хуудсанд нээлттэй зарлана.
3. Хоёрдугаар шатны оролцогч нь зохион байгуулагчдын зарласан цагт танхимаар олимпиад эхлэхээс 30 минутын өмнө иргэний үнэмлэх, оюутны үнэмлэхтэй ирж оролцоно.
4. 2-р шат нь татвар ногдуулалт, тайлагнал, бүртгэл бүхий цогц бодлого бодож, татварын тайлангийн маягт бөглөх хэлбэрээр явагдана.

Гурав: ШАЛГАРУУЛАЛТ

Нэгдүгээр үе шат:

- Оролцогчдын тестийг шалгалтын программ автоматаар дүгнэнэ.
- Тестийн зөв хариултыг шалгаруулалтын дараа www.cpta.mn, цахим хуудсанд нээлттэй байршуулна.
- Нийт оролцогчдын дүнг бүртгэлийн дугаараар шалгаруулалт хаагдсанаас хойш 24 цагийн дотор www.cpta.mn цахим хуудсанд нээлттэй мэдээлнэ.

Хоёрдугаар үе шат:

- Бүлэг тус бүрээс 2-р шатанд оролцох эрхээ авсан оролцогчид хамрагдана.
- Шалгалтын материалыг зохион байгуулах комиссын шийдвэрээр боловсруулна.
- Хоёрдугаар шатны дүнг шалгалт дууссанаас 24 цагийн дотор www.cpta.mn цахим хуудсанд нээлттэй мэдээллэн шагналт байруудыг тодруулна.

Дөрөв: ШАГНАЛ

Олимпиадын бүлэг тус бүрээс хамгийн өндөр оноо авсан эхний гурван байрыг дараах байдлаар шагнаж урамшуулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг Оюутан:

- ***1-р байр:*** 800,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,
- ***2-р байр:*** 500,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,
- ***3-р байр:*** 300,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,

Хоёрдугаар бүлэг Нягтлан бодогч:

- ***1-р байр:*** 1,500,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,
- ***2-р байр:*** 1,000,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,
- ***3-р байр:*** 500,000 төгрөг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр,

Олимпиадын шагналт байранд орсон оролцогч оюутнуудыг ТМЗ гишүүн байгууллагуудад ажлын байранд зуучилна.

Санаачлагч: Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг

Хамтран зохион байгуулагч: Бостон Стар Консалтинг ТМЗ ХХК

Холбоо барих: Бүртгэлтэй холбоотой мэдээллийг: 76118989 /5/

Зохион байгуулалттай холбоотой мэдээллийг: 76118989 /5/

Цахим хуудас: www.cpta.mn

Цахим хаяг: info@cpta.mn